

## “Соёмбо” маркийн дүрслэлийн асуудалд

Сундуйн Өлзиймаа<sup>1,\*</sup>

Бямбажавын Энхбат<sup>1</sup>

<sup>1</sup> Шинжлэх ухаан технологийн их сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль,

Дизайны салбар, Улаанбаатар, Монгол Улс

ORCID: <https://orcid.org/0009-0007-6126-9408>

ORCID: <https://orcid.org/0009-0008-6106-6747>

\* Холбоо барих зохиогч: [ulziimaa.s@must.edu.mn](mailto:ulziimaa.s@must.edu.mn)

**Хураангуй:** Монгол шуудангийн марк нь дэлхий нийтийн жишгээр харилцаа холбооны хэрэгсэл болох төдийгүй үндэсний дүрслэх урлаг, соёл, төр нийгмийн бодлого, түүхэн цаг үеийг харуулсан олон талт илэрхийлэл мөн болохыг “Соёмбо” маркийн дүрслэл дээр үндэслэн өгүүлэх болно. Мөн Монгол шуудангийн маркийн төрөл зүйлийг судлан өөрсдийн саналыг дэвшүүлж, тэдгээрийн дотроос үндэсний хэмжээний хоёр дахь марк болох “Соёмбо” маркийг бэлгэдэл, график дүрслэл, өнгө, зохиомж зэрэг дүрслэх урлагийн бүтээл болох талаас нь ажиглалт, харьцуулалт, тэмдэг зүй-бүтэц зүйн аргаар судалгаа хийж санал дүгнэлтээ дэвшүүлнэ.

**Түлхүүр үгс:** *дүрслэх урлагийн бүтээл, бэлгэдэл тэмдэг, зохиомж, дизайн, элемент*

## Comprehensive analysis on the design of Mongolian postage stamps:

### Case of “Soyombo” postage stamp

Ulziimaa Sundui<sup>1,\*</sup>

Enkhbat Byambajav<sup>1</sup>

<sup>1</sup> Department of Design, School of industrial Technology, Mongolian University of

Science and Technology, Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0007-6126-9408>

ORCID: <https://orcid.org/0009-0008-6106-6747>

\* Corresponding author: [ulziimaa.s@must.edu.mn](mailto:ulziimaa.s@must.edu.mn)

**Abstract:** This paper explains how the Mongolian national postal stamp is not only a tool of telecommunication according to international standards, but also an important and multifaceted symbol of national art and culture, state and social policy, and representative of the country’s history by analyzing the image of the national postal stamp named Soyombo. Moreover, the paper will examine the “Soyombo” stamp

based on the visual appearance of the stamp, such as symbols, graphics, colors, and compositions by observing, comparing, and using techniques of semiotics and structured methodology. Finally, this paper will suggest how to properly classify the stamps by conducting research and analysis on the types of stamps of the Mongolian post office.

**Keywords:** *visual art, symbol, composition, design, element*

## Оршил

Шуудангийн маркийг судлан үзэхэд олон талт мэдээллийн цогц шинж илэрдэг. Нэгдүгээрт, цаас, будаг, цавуу гэх мэт материалын шинж чанараараа тухайн цаг үеийнхээ хэвлэлийн материал, хэвлэх технологийг илтгэн харуулж байна. Хоёрдугаарт, марк нь тухайн улсын шуудангийн үйлчилгээний анхан шатны бүртгэлийн мэдээллийг өгдөг. Гуравдугаарт, эрх бүхий байгууллага болон хэрэглэгчийн хоорондын харилцааны баталгаа болсон тамга тэмдэгтүүдийг агуулсан нотлох баримт (M.Reid 1984, 223-249) болдог.

Марк нь өмнөх үетэй харьцуулахад өдөр тутмын амьдралд ховор ашиглагдаж байгаа ч улс орны тусгаар тогтнолын баталгаа, шуудангийн үйлчилгээний төлбөрийн хэрэгсэл, гадаад валют олох эх үүсвэр, уран сайхны бүтээл, тухайн ард түмний түүх, соёл урлаг, шинжлэх ухаан, шашин, угсаатны зүй, ёс заншил, байгаль, ан амьтныг дүрслэн үлдээсэн түүхэн баримт, сурталчилгааны хэрэгсэл зэрэг олон үүргийг нэгэн зэрэг гүйцэтгэдэг урлаг соёлын үнэт өв, соёлын бүтээлч үйлдвэрлэл юм (Болд 2022, 25).

Бид энэхүү судалгаагаараа шуудангийн марк нь нийгмийн харилцаа холбооны хэрэгсэл төдийгүй урлаг, соёлын олон талт илэрхийллийг шингээсэн үнэт зүйл мөн болохыг илрүүлэхийг зорьсон юм.

**Шуудангийн марк харилцаа холбооны хэрэгсэл болох нь:** Шуудангийн марк нь харилцаа холбооны гурван үндсэн үүрэг буюу хэрэглэгдэх, төлөөлөх, дурсгалын зорилготой байдаг. Шуудангийн марк нь Монгол Улсын тусгаар тогтнолыг илэрхийлсэн, шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталгаажуулсан, үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн төрөл (*Шуудангийн тухай хууль* 2019, УИХ) бөгөөд түүнийг хэрэглээнд оруулсны дараа шуудангийн маркийг дахин ашиглахаас зайлсхийхийн тулд үйлчилгээ үзүүлсэн огноо, газрыг заасан шуудангийн тамга тэмдэг ашиглан хүчингүй болгодог.


Монголчуудын шуудангийн маркийн түүх манай улсын тусгаар тогтнолын чухал үетэй зэрэгцэн улс орноо гадагшаа төлөөлсөн эрх чөлөө тусгаар тогтнолыг илтгэсэн дүр дүрслэлтэй, цаашлаад нийгмийн шилжилтийг илэрхийлэн бүтээгдэж байна. Улс орнууд түүхэн үйл явдал, шинжлэх ухаан, технологийн дэвшлээ шуудангийн маркаар харуулахыг зорих нь шуудангийн марк зөвхөн төлбөрийн хэрэгсэл төдий бус түүх, урлаг, соёлыг түгээгч гэдгийг илтгэнэ. Шуудангийн марк нь хэдийгээр жижиг хэмжээтэй ч ач холбогдлын хувьд суртал ухуулгын хамгийн тохиромжтой хэрэгсэл юм (Jack 2005). Аливаа улсын үндэсний хэмжээний тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан үйл явдал, урлаг, аж байдал, үнэт зүйл зэрэг тухайн улсын үндэс угсаа, соёл, нийгэм, түүхийн онцлогийг шуудангийн маркт уран

сайхны аргаар дүрслэн дотооддоо болон гадагшаа түгээн сурталчлах нь үндэстний бие даасан тусгаар тогтнолд итгэх итгэл үнэмшлийг бэхжүүлдэг байна. Марк нь өөрийн сэдвийн хүрээнд бусад урлаг, соёлын хэлбэрүүдээс илүү их төвлөрсөн, см квадрат дахь үзэл суртлын нэгдэл юм (Scott 1995, 25) гэж судлаачид тодорхойлжээ.

**Шуудангийн марк нь урлаг соёлын үнэт зүйл болох нь:** Урлаг соёлын объектив элементүүд нь уран зураг, архитектур, бүтээгдэхүүн зэрэг биет объектууд байдаг бол субъектив соёл нь нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйл, шашны зан үйл зэрэг биет бус элементүүдээс бүрддэг. Шуудангийн марк нь хүн төрөлхтөн бие биетэйгээ харилцах зорилгоор бүтээгдсэн бүтээгдэхүүн болохоос гадна бэлгэдлийн шинж чанартай байдаг тул урлагийн үнэт зүйлийн гол шинж чанарыг өөртөө агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нэг болно. Шуудангийн марк нь урлаг соёлын үнэт зүйл болохын тухайд судлаачид ард түмний соёл, иргэншил, соёлын үндсэн хэсгүүдийн нэг мөн бөгөөд гарал үүсэл, түүх, орчин тойрон нь жинхэнэ үнэ цэнийг нь тодорхойлж байдаг (Соёлын өвийн үндэсний төв 2018) ба соёл, археологи, түүх, уран зохиол, урлаг, шинжлэх ухааны ач холбогдолтой гэж улс бүр үнэлж байна. Мөн шуудангийн марк нь шашны буюу шашны бус шинж чанартай бөгөөд дээр дурдсан ангилалд хамаарагдаж байгаа зэргээс үзэхэд түүх, урлаг, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн жагсаалтад багтаж байна. Манай орон шуудангийн маркийг үйлдвэрлэх, борлуулах, хадгалах бодлогыг Монгол Улсын “Шуудангийн тухай” хуулиар (2019) зохицуулсан. Монголчуудын дүрслэх урлагийн нэгэн сонирхолтой төрөл зүйл нь үндэсний онцлогийг илэрхийлсэн шуудангийн марк юм.

### Судалгааны арга зүй

Бид Монгол шуудангийн маркийн энэхүү олон талт илэрхийллийг судлахдаа загварт дүн шинжилгээ хийх: маркийн загварыг ажиглалт, харьцуулалт, тэмдэг зүй-бүтэц зүйн судалгааны аргуудыг ашиглана. Шуудангийн маркийг мэдээлэл дамжуулах чадвартай өвөрмөц тэмдэг гэж үзэн тэмдэглэл, зураг дүрслэл, уриа лоозон, давтагдах сэдэв, түүхэн үзэгдэл, зан чанар, эв нэгдлийн илэрхийлэл, өнгөний хэрэглээ зэрэг дизайны янз бүрийн элементүүдийг үнэлнэ. Үнэлгээний шалгуурт: тэмдэглэлийн загварыг үнэлэх шалгууруудыг боловсруулах, үүнд хэвлэгдсэн улс, огноо, нэрлэсэн үнэ, давхардсан болон нэмэлт хураамж, дээр дурдсан загварын элементүүд хамаарна. Мөн марк дахь дүрслэлийн дүр, дүрс болон бэлгэдлийн агуулгыг тодруулна (Зураг 1).



Зураг 1. Шуудангийн маркийг судлах процесс

Судалгааны үр дүн

Монголын шуудангийн маркийг он цаг, агуулга дүрслэлээр нь маркийн зураач Т.Отгонбаяр нийт 73 жилийн маркийн загварыг гурван (*Хүснэгт 1*) хэсэгт авч үзээд, сэдвийн хувьд улс төр, урлаг соёл, спорт, шинжлэх ухаан, техник, байгаль гэж тав (Болд 2022, 165) ангилжээ.

Хүснэгт 1


1924-1958 он	1958-1983 он	1983-1997 он
Маркийн хөгжлийн эхэн үе	Маркийн алтан үе	Маркийн гүн хямралын үе

Бид судалгаагаараа утга агуулга дүрслэлийн хувьд илүү нарийвчлан ангилах шаардлагатай гэж үзэн дөрвөн мянга гаруй маркийг нийт 14 төрөлд хуваан (*Хүснэгт 2*) ангилсан юм.

Хүснэгт 2

№	Маркийн сэдвийн ангилал	Хамаарагдах тоо
1	Улс төр	89
2	Хөрөг	448
3	Шашин	108
4	Бэлгэдэл	141
5	Байгаль, ан амьтан, ургамал	1346
6	Нийгэм	136
7	Шинжлэх ухаан	215
8	Спорт	448
9	Үйл явдал	361
10	Соёл урлаг	532
11	Дүрслэх урлаг	102
12	Хүүхэд	300
13	Тээвэр	262
14	Хот-барилга архитектур	76

Эдгээрээс “Бэлгэдлийн агуулгатай” маркийг (1924-2024) тоон үзүүлэлтээр харуулахад очир, соёмбо, сүлд зэрэг дүрслэлтэй марк хамаарагдсан 100 жилийн хугацаанд нийт 138 ширхэг хэвлэгдсэн (*Зураг 2*) байна. Тухайлбал, монголын хоёрдогч марк болох “Соёмбо” марк нь дээрх агуулгад багтаж байна.



Зураг 2. 1924-2024 оны хугацаанд “Бэлгэдлийн агуулгатай” маркийн тоон үзүүлэлт

Шуудангийн маркийн зураглал нь “Үндэстний тухай ойлголт”-ыг дамжуулдаг бөгөөд энэ нь тухайн үндэстэн эсвэл улс орныг тодорхой хугацааны туршид хэрхэн төлөөлөх түүх, соёл, өвөрмөц байдлын талаарх төрийн бодлого шингэсэн сурталчилгаа юм. Монгол орны нийгэм, улс төр, цаг үеийн өөрчлөлтийн явцад дугтуйн дээр зураг, тэмдэгт, тамга ашиглаж байсныг өөрчилж цавуу бүхий шуудангийн анхны наадаг маркийг 1924 оны 7 дугаар сарын 1-нд М.Бат-Очирын санаачилснаар “Элдэв Очир” нэртэйгээр чулуун барын аргаар хэвлүүлсэн (Н.Төмөрхүү 2011, 297). “Элдэв Очир” маркийг 1, 2, 5, 10, 20, 50 цент, 1 долларын нэрлэсэн үнэтэйгээр 7 нэгж хэвлэн худалдаанд гаргасныг *Зураг 3-т* үзүүлэв.



*Зураг 3. Монголын анхны “Элдэв Очир” марк*

Ингэж Монгол Улсын шуудангийн анхны марк бий болсон нь тусгаар тогтносон бүрэн эрхт улс гэдгээ баталсан чухал ач холбогдолтой үйл явдал болсон. 1924 онд Бүгд Найрамдах Улсаа тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталснаар “Соёмбо” тэмдэг нь шинэ Монгол Улсын сүлд болсон. 1926 оны 2 дугаар сарын 25-нд гүйлгээнд гарсан монголын хоёрдогч марканд (*Хүснэгт 3*) “Соёмбо” бэлгэ тэмдгийг дүрсэлсэн байна. “Соёмбо” нь бичиг үсгийн дурсгал бөгөөд Өндөр гэгээн Занабазар 1686 онд эртний энэтхэгийн ланз бичигт тулгуурлан зохиожээ. Тус бичгийг улс төр, соёлын зорилгоор зохиосон агаад монголын тусгаар тогтнол, бие даасан байдлыг бэлгэдэх, бурхны шашны ном зохиол орчуулахад монгол, санскрит, түвд үгийг бүрэн тэмдэглэхийг зорьсон ажээ (Монголийн түүхийн тайлбар толь 2016). XX зууны эхээр монголчууд тусгаар тогтнолоо зарлан тунхагласны дараа соёмбо бичгээр төрийн тамга, тэмдгийн бичээсийг бичих, тус бичгийн эхлэлийн үсэг болох “соёмбо” дүрсийг тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болгон тамга, туг далбаа, мөнгөн тэмдэгт, шуудангийн марк зэрэгт дүрслэх болжээ.

“Соёмбо” шуудангийн марк нь 1926-1932 онд шинээр дөрвөн дугаар хэвлэгдэж нийт 25 нэгж, мөн 14 нэгжийг дахин бичвэр хийж хэвлэн эргэлтэд оруулсан байна.


### **“Соёмбо” маркийн дүрслэл**

“Соёмбо” маркийн нийт форматын 1/4 хувьд нь тухайн марк тус бүрийн үнийг монгол болон араб тоогоор, түүний хажуу болон доод хэсэгт мөнгөн тэмдэгтийн нэгжийг монгол бичгээр “мөнгө, төгрөг”, кириллээр “цент, доллар” гэж бичжээ. Энэ нь тухайн үед манай улсад төгрөг (үндэсний валют) хараахан төлөвшөөгүй байсантай холбоотой. Ингэж марк дээрээ үнийг бичсэнээр шуудангийн марк төлбөр хураалгасны тэмдэг болж, захидал, бичиг зэрэгт нааж ашиглах шуудангийн марк болдог. Энэ нь Монгол Улсын тусгаар тогтнолыг илэрхийлсэн, шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталгаажуулсан, үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн төрөл гэсэн тодорхойлолтуудад бүрэн нийцэх болсон. Гэсэн хэдий ч тухайн цаг үеийн шилжилтээс хамаарч анхны соёмбот марк дээрээ улсын нэрээ мөн бичээгүй “Улсын тэмдэг” гэсэн үгийг монгол бичгээр бичин хэвлэсэн байна.

Хүснэгт 3. “Соёмбо” шуудангийн маркийн төрөл зүйл (1926-02-25)

Маркийн код	Маркийн зураг	Нэрлэсэн үнэ	Хэмжээ (мм)
C1		1 цент	22x34
C2		2 цент	22x35
C3		5 цент	22x36
C4		10 цент	22x35
C5		20 цент	22x35
C6		50 цент	26x44
C7		1 доллар	28x34
C8		5 доллар	28x44
C9		25 доллар	35x45

“Соёмбо” шуудангийн марк нь (цаашид хүснэгт эрэмбэлсэн дарааллаар нь C1, C2, C3, C4, C5, C6, C7, C8, C9 гэх) төлбөрийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэхээс гадна түүнээс нэн тэргүүний үүрэг болох эх орныхоо түүх, угсаатны зүй, ёс заншил, соёл урлагийг таниулах, сурталчлах үүрэгтэй болсон.



C1 маркийн график элементүүд

1. Үндсэн график: Соёмбо
2. Дэвсгэр хээ 1: Бадам
3. Дэвсгэр хээ 2: Ургамалжин
4. Маркийн хүрээ: Өргөн нарийн давхар хүрээ
5. Бичвэр: “Улсын тэмдэг” үндэсний бичгээр
6. Бичвэр: “Мөнгө”, “цент, доллар” нэрлэсэн үнийн бичвэр үндэсний болон крилл үсгээр
7. Бичвэр: “1” нэрлэсэн үнийн дүн, араб, үндэсний үсгээр
8. Маркийн шүд (огтолгооны хэлбэр)

Зураг 4. Монголын хоёр дахь марк “Соёмбо”

“Соёмбо” маркийн элементүүдийг дүрслэлийн хувьд авч үзвэл үндсэн график, дэвсгэр хээ, маркийн хүрээ, бичвэр, маркийн шүд зэрэг дараах элементүүдээс бүрдэж байна (Зураг 4). Маркт тавигдах шаардлагын (К.Н.Сабур 2019) гол элемент болох улсын нэр тус есөн нэгж марк дээр бичигдээгүй боловч найман сарын дараа буюу 1926 оны 11 дүгээр сарын 5-нд хэвлэгдсэн хоёр нэгж “Соёмбо” маркаас эхлэн үндэсний бичиг үсгээр “Бүгд Найрамдах Монгол улс”, латинаар “Mongolia” бичиж эхэлсэн (Зураг 5).





Зураг 5. Монгол Улсын нэр бичигдсэн анхны “Соёмбо” марк




Зураг 6. Монголын анхны “Соёмбо” марк

### С1-С9 маркийн дүрслэлийн зохиомж

Тус маркуудыг тэгш хэмийг баримтлан хоёр тал нь төв тэнхлэгээр бие биеийнхээ толин ойлт байхаар дүрслэжээ (Зураг 6). Учир нь төв хэсэгт нь “Соёмбо” тэмдгийг эргэн тойрны ургамалжин хээгээр тодосгож, дэвсгэрийн төвд тэгш хэмтэй тодотгож харуулсан. Өнгөний хувьд С1-С5 хүртэл үндсэн дүрслэл ба дэвсгэр хээг дан өнгөөр, С6-С9 маркийг хоёр өнгөөр илэрхийлсэн. Маркийн графикийн арын дэвсгэр дэх олон төрлийн ургамалжин хээг үндсэн дүрс ба дэвсгэрийн зохицлын онолын аргаар тайлбарлавал, гол дүрсийг орон зайд ойрхон байрлуулсан мэт сэтгэгдэл төрүүлнэ, харин арын дэвсгэр нь үндсэн дүрсийг орон зайд илүү тод харагдуулахын тулд жигд хэмнэлтэй, жижиг дүрслэлтэй байна. Үндсэн дүрслэл болох “Соёмбо”-ыг зурсан арга барил хэв маягийн хувьд есөн өөр график зураглалаар чөлөөтэй зурж дүрслэгдсэн нь анхны “Элдэв Очир” маркийн зураглалтай харьцуулахад Б.Шаравын өөр нэг арга барилыг илтгэнэ.

C1-C9 хүртэлх есөн марк дээр дүрслэгдсэн “Соёмбо” нь өөр өөр график илэрхийлэл зураглалаар дүрслэгдэж, харьцааны хувьд хоорондоо эрс ялгаатай байна. Соёмбын өргөн нь модуль [a] тохиолдолд өндрийн харьцаа [1.6a]-[2a] хүртэл зөрүүтэй, захын хоёр баганын өргөн жигд бус төгсгөл нь өөр байна. Оройн дүрслэл болон голын арга бэлгэ дүрсийн харьцаа алдаатай зэргээр дүрсэлсэн байгаа нь төрийн бэлгэдэл “Соёмбо” анх зохигдсоноос хойш тогтсон харьцааны системд ороогүй зөвхөн хувь уран бүтээлчийн график илэрхийллээр дүрслэгдэж байж (Зураг 7).



Зураг 7. “Соёмбо” маркийн соёмбын харьцаа

### C1-C9 маркийн бичвэрийн зохиомж

“Соёмбо” маркийн бичвэрийн хувьд тус бүрийн хавтгайд дүрсэлсэн нийт дүрслэлийн хэмжээнээс хамаарч бичвэрүүд тогтсон хэв маягт баригдаагүй. C1-C8 хүртэлх маркийн бичвэр тухайн хавтгайн доод хэсэгт 2,2-5 мм өндөртэйгөөр үндэсний бичиг болон кирилл үсгээр илэрхийлсэн байна. Тухайн хэмжээс нь үндсэн дэвсгэрийн 1/9 харьцаатай байгаа нь гол дүрсний харагдах байдалд төвөг болохгүй ба өнгийн хувьд дан нэг өнгөөр хэвлэгдсэн нь нэрлэсэн үнэ болон мөнгөний нэгжийг ялган харахад бага зэрэг төвөгтэй дүрслэгдсэн байна. C9 маркийн хувьд дээд хоёр тоог 5 мм үндэсний бичгээр, доод нэг тоог өндөр 5 мм хэмжээтэйгээр араб тоогоор илэрхийлсэн байна. “Улсын тэмдэг” гэсэн үг нь C1-C9 маркийн соёмбын хоёр талаар үндэсний бичгээр бичигдсэн байна.

### C1-C9 маркийн дүрсийн бэлгэдэл

Соёмбо бол Монгол төрийн бэлгэ тэмдэг бөгөөд соёмбын орой хэсэгт байдаг “Гурван үзүүртэй гал” бол өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагт балчир, идэр, өтгөс гурван үеэрээ үүрд мандахын утгатай болно. Түүний доор байгаа “нар сар” хоёр бол мөнх тэнгэрийг төлөөлөн эгнэгт батжин бэхжих, энхжин мөнхжихийн бэлгэдэл юм (Болд 2001, 263). Энэхүү гал, нар, сар гурав нийлээд Монгол улс бадран мандах болтугай гэсэн утга хадгалжээ. “Гурвалжин дүрс” бол жад болон сумны гилбэрийг дүрсэлсэн бөгөөд үзүүрийг доош харуулсан нь дайсныг дарна



гэсэн утгатай. Дээд гурвалжин нь дотоодын дайсныг, доод гурвалжин нь гадаадын дайсныг дарах утгатай юм (Шагдарсүрэн 2001, 133). Дээд гурвалжны доор, доод гурвалжны дээр байх “хэвтээ дөрвөлжин” нь шулуун шударга, бат бөх журамтай байхыг бэлгэдсэн байна. Голд байх “дугариг дүрс” бол хос загасны дүрс бөгөөд загасыг монголчууд өдөр шөнийн цагт нүдээ аньдаггүй, үр төл ихтэй амьтан гэж сонор, соргог, өнөр өтгөнийг дүрслэхдээ хэрэглэдэг заншилтай. Соёмбын хоёр хажуугийн “босоо дөрвөлжин” нь хэрмийг дүрсэлсэн тэмдэг бөгөөд энэ нь монголын бүх ард түмэн эх орныхоо төлөө эв сэтгэл нэгтэй бол төмөр хэрмээс ч бат бөх гэсэн утга санааг хадгалжээ. Ийнхүү дээрх утга бэлгэдлийг шингээн монголын хоёрдогч марк дээр соёмбыг дүрсэлжээ.

### Хэлэлцүүлэг

Соёмбын сууринд бадам хээ, маркийн дэвсгэрт янз бүрийн ургамалжин хээг ашигласан нь монголчуудын эртнээс байгалиа шүтэн дээдэлж дүрслэх урлагтаа ихээхэн ашиглаж ирсний илрэл. Учир нь урган соёолох, өсөн төлжихүйн болон цэцэглэн мандахуйн бэлгэдэл утгыг аль алийг нь илтгэн (Дулам 2020, 156) тухайн цаг үеийн байдлыг дээшлэн дэвжихийг ерөөн дүрсэлсэн. Бадамлянхуа цэцэг нь буддын шашны зүйрлэлийг илэрхийлдэг. Энэхүү үзэсгэлэнт цэцэг намаг дунд цэцэглэдэг бөгөөд энэ нь эхлэл цэг нь хамаагүй ямар ч зүйл сэрэлтэд хүрэх боломжийг илэрхийлдэг гэж үзэн соёмбын суурь болгон дүрсэлсэн байна.



Зураг 8. Хас тэмдэг дүрслэгдсэн “Соёмбо” марк (С6 буюу 50 цент)

“Соёмбо” марк (С6 буюу 50 цент) марк дээр монголын эртний бэлгэдлийн дүрс болох хас тэмдгийг тэр дундаа нар зөв, нар буруу эргэсэн бүрэн зэтэртэй хасыг арга билгийн хослолыг бүтээн дүрсэлсэн байна (Зураг 8). Хас нь хамгийн эртний бөгөөд урт удаан түгээмэл хэрэглэгдэж байгаа бэлгэдэл тэмдэг юм. Улс орон бүр хасыг өөр өөрийнхөөрөө тайлбарладаг бөгөөд монголчууд өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт хүчирхэг байх үзүүр бүгд нь дуусашгүй, түмэн настай, түмэн үед оршихын бэлгэдэл хэмээдэг (Болд 2022, 64). Мөн түүнчлэн бүрэн зэтэртэй хасыг хүний үйл бүтээлийн аль эрхэм хүндэтгэлтэй зүйлд хүндэтгэн бэлгэддэгийн (Дулам 2020, 52) үүднээс тус марк дээр орон зай, цаг хугацаанаас үл хамааран дөрвөн зүг найман зовхист шуудан харилцааны үйл хэргийг саадгүй бат бөх түгээхийг илтгэн дүрсэлжээ.

## Дүгнэлт

Уг судалгааны ажлын хүрээнд дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- “Соёмбо” марк нь сэдэв, зохиомж, агуулгын хувьд орчин үеийн маркийн шинэ график илэрхийллийг үүсгэсэн, өнөөгийн маркийн хэв шинжийг үндэслэсэн бүтээл гэж үзэж, уг маркийн график элементүүдийг тодорхойллоо.
- “Соёмбо” маркийн график элементүүдийн хувьд үндсэн дүрсээр “Соёмбо”, арын дэвсгэрт олон төрлийн ургамалжин хээг дүрсэлсэн. Зохиомжийн хувьд үндсэн дүрсийг орон зайд илүү ойрхон байрлуулсан мэт сэтгэгдэл төрүүлж, харин арын дэвсгэр нь гол дүрсийг илүү тод харагдуулахын тулд жигд хэмнэлтэй, жижиг дүрслэлээр илэрхийлсэн.
- Маркт тавигдах шаардлагын гол элемент болох Монгол Улсын нэр анхны маркт бичигдээгүй байсан нь 1923-1924 онд манай орны улс төр, нийгмийн шилжилтийн үеийн нөхцөл байдлыг илэрхийлж, 1926 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2 нэгж марк дээр Монгол Улсын нэр анх удаа бичигдсэн байна.
- Соёмбо анх зохиогдсоноосоо хойш тогтсон харьцааны системд ороогүй зөвхөн хувь уран бүтээлчийн график илэрхийллээр дүрслэгдэж байсныг тогтоолоо.

## Ашигласан материалын жагсаалт

- Jack, Child. 2005. “The Politics and Semiotics of the Smallest Icons of Popular Culture: Latin American Postage Stamps.” *Latin American Research Review*, Volume 40, Number 1: 108-137.
- Donald M.Reid. 1984. “The symbolism of postage swtamps a source for the historian.” *Journal of Contemporary history*, Vol. 19: 223-249. <https://www.jstor.org/stable/260594>
- David H.T.Scot 1995. *European Stamp Design: A Semiotic Approach to Designing Messages*. London: Academy Editions.
- Болд, Л., Бат-Ирээдүй, Ж. 2001. *Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон*. Улаанбаатар: Эдмон ХХК.
- Болд, Чимэд-Осор. 2022. *Монгол маркийн түүх*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Дулам, С. 2020. *Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*. Улаанбаатар: Битпресс ХХК.
- К.Н.Сабур, М.Э.Вильчинской-Бутенко. 2019. “Системный подход к созданию дизайна почтовой марки.” *Труды института бизнескоммуникаций* 51-58.
- Монголийн түүхийн тайлбар толь*. т.ү. “Монголийн түүх.” 2016. <https://mongoltoli.mn>.
- Соёлын өвийн үндэсний төв. 2018. “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд юуг хамааруулах бэ?” <https://ncch.gov.mn/tangible>.
- Төмөрхүү, Н. 2011. *Монгол шуудангийн түүхэн товчоон*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Шагдарсүрэн, Ц. 2001. *Монголчуудын бичиг үсгийн товчоон*. Улаанбаатар: Урлах эрдэм.